



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
АРБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 11 сарын 14 өдөр

Дугаар А/132

Мандал

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9 дэх заалт, 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Аймгийн засаг даргын тамгын газрын 2024 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн 1/2026 дугаар албан бичгийн тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бүгд Найрамдах Улсыг тунхаглаж, Анхдугаар үндсэн хууль баталсны 100 жилийн ойн арга хэмжээг орон нутагт төлөвлөгөөний дагуу зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Ганхуяг (Засаг даргын тамгын газрын дарга)
Л.Даваадорж (Ерөнхий боловсролын сургуулийн захирал)
С.Бат-Эрдэнэ (Иргэдийн төлөөлөгчдийн хурлын нарийн бичгийн дарга)
Ч.Саранцэцэг (Сургуулийн өмнөх боловсролын эрхлэгчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)
О.Наранхүү (Эрүүл мэндийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)
Б.Цэндбаяр (Санхүү албаны дарга)
М.Хэнчбиш (Соёлын төвийн эрхлэгч)
Б.Болдсайхан (Хэсгийн төлөөлөгч, цагдаагийн дэслэгч)
Нарийн бичгийн дарга: З.Батцэцэг (Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

2.Төлөвлөгөөнд заасны дагуу баг, байгууллагын дарга, эрхлэгч нар холбогдох албан хаагчдыг үүрэгжүүлэн ажиллуулж үр дүнг танилцуулан тайлан мэдээг нэгтгэн заасан хугацаанд нь хүргүүлэхийг ажлын хэсгийн ахлагч, гишүүдэд үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөө хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг байгууллагын холбогдох зардлаас тооцож гаргахыг (Байгууллагын дарга эрхлэгч нарт) зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (Ц.Ганхуяг)-т даалгасугай.

ДАРГА

С.АЮУШЖАВ



D:\2024 ОН\захирамж.docx



ЗАСАГ ДАРГА БАТЛАВ С. АЮУШЖАВ

2024 оны ... сарын ... -ын өдөр

БҮГД НАЙРАМДАХ УЛСЫГ ТУНХАГЛАЖ, АНХДУГААР ҮНДСЭН ХУУЛИА БАТАЛСНЫ
100 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХ ХҮРЭЭНД
ХИЙХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцан зохион байгуулах байгууллага, албан тушаалтан
1	Анхдугаар үндсэн хуулийн түүхэн ач холбогдлыг харуулсан контент хийж цахимаар сурталчлах	11 дүгээр сарын 20-ны өдрөөс 26-ны хооронд	ЗДТГ, Б.Энхзаяа, З.Батцэцэг
2	Шатар сонирхогчдын сум-ын аварга шалгаруулах тэмцээнийг хүүхэд болон насанд хүрэгчдийн дунд зохион байгуулах	11 дүгээр сарын 25-ны өдөр	ЗДТГ, ИТХ, С.Бат-эрдэнэ, М.Тайванжаргал
3	Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад анхдугаар Үндсэн хууль, улс орны тусгаар тогтнол, бүрэн эрхэд байдлаа зарласантай холбоотой сургалт хэлэлцүүлэг хийх	11 дүгээр сарын 25-ны өдөр	Ерөнхий боловсролын сургууль, Л.Даваадорж, Монгол хэл уран зохиол, түүх, нийгмийн багш нар
4	Ахлах, дунд ангийн сурагчдын дунд "Тусгаар тогтнол, Үндсэн хууль"-ийн сэдвийн хүрээнд "Эсэ" бичлэгийн уралдаан зарлаж эхний 3 байрыг шалгаруулан шагнаж урамшуулах	11 дүгээр сарын 15-ны өдрөөс 21-ны хооронд	Ерөнхий боловсролын сургууль, Л.Даваадорж, Монгол хэл, уран зохиол, түүх, нийгмийн багш нар
5	Цолгүй залуу 32 бөхийн барилдааныг зохион байгуулах	11 дүгээр сарын 25-ны өдөр	ЗДТГ, ЕБС, Соёлын төв, Б.Нямжав, Б.Очир, Ш.Болдбаатар
6	Төрийн албан хаагчдад, иргэдийг хамруулсан түүхэн сэдэвтэй холбоотой "АХА" тэмцээн зохион байгуулах	11 дүгээр сарын 25-ны өдөр	ЭМТ, СӨБ О.Наранхүү, Ч.Саранцэцэг
7	Үндсэн хуулийн 100 жилийн ой, тусгаар тогтнолыг өдөрт зориулсан өдөрлөг, хаалтын арга хэмжээг зохион байгуулах	11 дүгээр сарын 25-ны өдөр	Соёлын төв М.Хэнчбиш